ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/92/СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Дагвасүрэн
Утас:99014227
Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn

Аудитор Ц.Оюунсувд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........ **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3

3. Аудитын тайлан ........ 12

   3.1 Ерөнхий зүйл ........ 12

   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12

   3.4 Материаллаг байдал ........ 13

   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13

   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13

   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14

   3.8 Аудитын гол асуудал ........ 14

   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14

   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15

4. Аудитын илрүүлэлт ........ 15

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/274

танай ________ -ны № ________ -т

АЛДАРХААН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЛХАГВАЖАРГАЛ-д

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Audit(D)A4-тоот/2022

01302526

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **30,998,654.07** | **125,334,729.05** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 1,786,588.98 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 1,786,588.98 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 1,786,588.98 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 857,660.36 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 00.00 | 928,928.62 |
| **33** | **АВЛАГА** | 229,124.00 | 84,603,400.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 229,124.00 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 84,603,400.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 30,769,530.07 | 38,944,740.07 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,773,258.18 | 3,421,258.18 |
| 35130 | Эм боох материал | 2,773,258.18 | 3,421,258.18 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 705,000.00 | 705,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,291,271.89 | 34,818,481.89 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 84,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,557,162.00 | 4,557,162.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,899,000.00 | 1,899,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 860,000.00 | 860,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,470,740.01 | 2,246,740.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,504,369.88 | 25,171,579.88 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **262,224,429.55** | **1,239,532,549.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 262,224,429.55 | 1,239,532,549.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 249,289,763.03 | 1,226,664,549.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 235,741,183.00 | 1,293,763,481.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -26,136,802.11 | -205,271,668.79 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 41,876,322.60 | 84,876,322.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -19,539,790.53 | -24,842,227.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 49,655,144.43 | 118,652,101.99 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -40,328,493.66 | -47,038,653.35 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,965,959.35 | 20,965,959.35 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,388,093.44 | -14,761,099.10 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 620,000.00 | 620,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -175,666.61 | -299,666.57 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12,934,666.52 | 12,868,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -941,333.48 | -1,008,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,868,000.00 | 12,868,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **293,223,083.62** | **1,364,867,278.80** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,643,701.79** | **43,682,383.93** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,643,701.79 | 43,682,383.93 |
| **413** | **Өглөг** | 5,643,701.79 | 43,682,383.93 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,078,701.79 | 33,994,952.93 |
| **4136** | **Бусад өглөг** | 565,000.00 | 9,687,431.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 565,000.00 | 9,687,431.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **287,579,381.83** | **1,321,184,894.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 287,579,381.83 | 1,321,184,894.87 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 150,708,260.50 | 150,708,260.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 150,708,260.50 | 150,708,260.50 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -50,100,137.60 | 983,505,375.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -50,100,137.60 | -50,100,137.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,033,605,513.04 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 186,971,258.93 | 186,971,258.93 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **293,223,083.62** | **1,364,867,278.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **413,723,499.06** | **1,829,973,617.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **59,325,089.06** | **1,189,089,427.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,653,369.06 | 1,189,089,427.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,160,269.06 | 1,189,089,427.56 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,160,269.06 | 1,189,089,427.56 |
| 120009 | Бусад орлого | 28,493,100.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 27,671,720.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 27,671,720.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **12,897,410.00** | **276,289,690.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 341,501,000.00 | 364,594,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 30,942,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 30,942,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 39,493,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 39,493,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 12,897,410.00 | 205,854,190.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 12,897,410.00 | 205,854,190.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **423,531,992.37** | **796,368,104.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **423,531,992.37** | **796,368,104.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 422,994,510.37 | 766,368,104.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 280,304,006.00 | 343,954,654.72 |
| 210101 | Үндсэн цалин | 280,304,006.00 | 343,954,654.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,325,258.00 | 18,746,735.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,772,873.00 | 18,746,735.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,527,891.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,323,977.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 518,231.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,182,286.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,568,501.79 | 67,406,051.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,800,986.99 | 2,818,401.73 |
| 210302 | Түлш, халаалт | 30,767,514.80 | 64,587,649.41 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,269,401.00 | 18,517,877.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,064,800.00 | 1,266,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,152,101.00 | 15,360,477.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,427,800.00 | 1,469,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 406,000.00 | 422,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 218,700.00 | 00.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 33,473,850.00 | 95,967,442.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,663,390.00 | 81,892,365.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,810,460.00 | 13,442,077.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 633,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 802,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 802,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 303,700.00 | 388,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 303,700.00 | 388,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 457,800.00 | 56,949.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 70,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,000.00 | 54,120.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 14,800.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | 2,829.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 45,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,291,993.58 | 220,528,295.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,003,013.00 | 27,817,160.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,288,980.58 | 192,711,135.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 537,482.00 | 30,000,000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 30,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 30,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 537,482.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 537,482.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-9,808,493.31** | **1,033,605,513.04** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-9,808,493.31** | **1,033,605,513.04** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | 150,708,260.50 | 186,971,258.93 | -40,291,644.29 | 297,387,875.14 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **150,708,260.50** | **186,971,258.93** | **-40,291,644.29** | 297,387,875.14 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -9,808,493.31 | -9,808,493.31 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **150,708,260.50** | **186,971,258.93** | **-50,100,137.60** | 287,579,381.83 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **150,708,260.50** | **186,971,258.93** | **-50,100,137.60** | 287,579,381.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **150,708,260.50** | **186,971,258.93** | **-50,100,137.60** | 287,579,381.83 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,033,605,513.04 | 1,033,605,513.04 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **150,708,260.50** | **186,971,258.93** | **983,505,375.44** | 1,321,184,894.87 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **410,563,230.00** | **556,280,790.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,164,820.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 28,493,100.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 28,493,100.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 27,671,720.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 27,671,720.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **354,398,410.00** | **556,280,790.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 341,501,000.00 | 364,594,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 30,942,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 30,942,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 39,493,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 39,493,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 12,897,410.00 | 121,250,790.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 12,897,410.00 | 121,250,790.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **409,696,230.00** | **548,144,201.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **409,696,230.00** | **548,144,201.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **409,158,748.00** | **518,144,201.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 276,905,351.00 | 323,149,666.02 |
| 210101 | Үндсэн цалин | 179,049,077.00 | 180,608,455.02 |
| 210102 | Нэмэгдэл | 74,509,377.00 | 111,163,737.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,534,000.00 | 4,691,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,812,897.00 | 26,686,474.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,388,037.00 | 39,887,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,319,400.00 | 28,069,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,770,500.00 | 2,954,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,216,400.00 | 2,363,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,903,114.00 | 590,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,178,623.00 | 5,909,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,489,800.00 | 38,489,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,800,986.99 | 2,818,401.73 |
| 210302 | Түлш, халаалт | 25,641,813.01 | 35,671,398.27 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 47,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,622,701.00 | 18,601,877.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,044,800.00 | 1,350,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,152,101.00 | 15,360,477.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,427,800.00 | 1,469,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 406,000.00 | 422,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 592,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,503,281.00 | 68,816,649.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,854,925.00 | 53,885,572.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 3,916,956.00 | 14,298,077.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,731,400.00 | 633,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 90,000.00 | 802,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 90,000.00 | 802,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 303,700.00 | 388,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 303,700.00 | 388,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 457,800.00 | 56,949.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 70,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,000.00 | 54,120.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 14,800.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | 2,829.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 45,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,398,078.00 | 27,951,560.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,398,078.00 | 27,951,560.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **537,482.00** | **30,000,000.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 30,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 30,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 537,482.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 537,482.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **867,000.00** | **8,136,588.98** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **867,000.00** | **6,350,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **867,000.00** | **6,350,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 867,000.00 | 6,350,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 867,000.00 | 6,350,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-867,000.00** | **-6,350,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 1,786,588.98 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 1,786,588.98 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 433,410,000.00 | 407,459,129.64 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 433,410,000.00 | 407,459,129.64 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 432,750,000.00 | 407,459,129.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 295,464,000.00 | 295,463,999.64 |
| 210101 | Үндсэн цалин | 177,838,900.00 | 152,922,788.64 |
| 210102 | Нэмэгдэл | 85,362,700.00 | 111,163,737.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,566,000.00 | 4,691,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,696,400.00 | 26,686,474.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,887,600.00 | 39,887,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,069,100.00 | 28,069,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,954,600.00 | 2,954,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,363,700.00 | 2,363,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 590,900.00 | 590,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,909,300.00 | 5,909,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,489,800.00 | 38,489,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,161,000.00 | 2,818,401.73 |
| 210302 | Түлш, халаалт | 37,216,200.00 | 35,671,398.27 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 112,600.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,141,700.00 | 14,051,377.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,525,600.00 | 1,037,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,533,100.00 | 11,260,477.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,680,000.00 | 1,331,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 881,100.00 | 422,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,461,900.00 | 00.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 22,645,600.00 | 12,640,663.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 15,743,800.00 | 7,013,736.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,170,400.00 | 4,993,927.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,731,400.00 | 633,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,603,300.00 | 802,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,118,200.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 481,800.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,003,300.00 | 802,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,621,000.00 | 388,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,621,000.00 | 388,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 907,800.00 | 56,949.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 70,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68,000.00 | 54,120.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 14,800.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | 2,829.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 45,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 450,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9989200.00 | 5678641.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,989,200.00 | 5,678,641.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 660000.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 660,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 660,000.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 433,410,000.00 | 43,722,290.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 364,764,700.00 | 00.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 364,764,700.00 | 00.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 39,493,100.00 | 39,493,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 39,493,100.00 | 39,493,100.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,152,200.00 | 4,229,190.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,152,200.00 | 4,229,190.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 857,660.36 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 22 | 22 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗА | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **147,035,071.38** | **147,035,071.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **147,035,071.38** | **147,035,071.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 117,035,071.38 | 117,035,071.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 27,685,666.38 | 27,685,666.38 |
| 210101 | Үндсэн цалин | 27,685,666.38 | 27,685,666.38 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,550,500.00 | 4,550,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 313,000.00 | 313,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,100,000.00 | 4,100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 137,500.00 | 137,500.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 56,175,986.00 | 56,175,986.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 46,871,836.00 | 46,871,836.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,304,150.00 | 9,304,150.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28622919.00 | 28622919.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,622,919.00 | 28,622,919.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 30000000.00 | 30000000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 30942400.00 | 30942400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 30,942,400.00 | 30,942,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 30,942,400.00 | 30,942,400.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй  холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын  газрын аудитор Ц.Оюунсувд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа  хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022  оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алдархаан сумын Эрүүл мэндийн төв нь “Зөв зан үйлийг төлөвшүүлж, хүн амын өвчлөл нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасгах” зорилго тавин ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт орлогоос 556.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

*/мян.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Төрийн сангийн харилцах | | 1,786.6 | 1,786.6 |
| Авлага | 229.1 | 84,603.4 | 84,374.3 |
| Бараа материал | 30,769.5 | 38,944.7 | 8,175.2 |
| Үндсэн хөрөнгө | 262,224.4 | 1,239,532.5 | 977,308.1 |
| **Нийт хөрөнгө** | **293,223.1** | **1,364,867.3** | **1,071,644.2** |
| Өр төлбөр | 5,643.7 | 43,682.4 | 38,038.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 287,579.4 | 1,321,184.9 | 1,033,605.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **293,223.1** | **1,364,867.3** | **1,071,644.2** |

Бараа материалын дансны үлдэгдэл 8,175.2 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 648.0 мянган төгрөгөөр, хангамжийн материал 7,527.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 977,308.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 43,000.0 мянган төгрөгийн автомашин, 1,058,022.3 мянган төгрөгийн барилга, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 62,646.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдсэн, төсвийн хөрөнгөөр 6,350.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,033,605.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 433,410.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 433,410.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 364,594.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39,493.1 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 4,229.2 мянган төгрөгийн, нийт 408,319.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 30,942.4 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 117,021.6 мянган төгрөгийн, нийт 147,964.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос 117,035.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 30,000.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь зардлын эдийн засгийн ангиллыг гүйлгэн зарцуулсан, худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй байна. Тус байгууллагын дотоод хяналтын нэгж санхүүгийн үйл ажиллагаандаа хяналт тавьж байгаа боловч хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 143 мэдээллээс 120 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, хугацаа хоцорсон мэдээлэл 23 байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 273,018.7 мянган төгрөгийн орлого, 155,565.5 мянган төгрөгийн зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 84,603.4 мянган төгрөгийн авлага, 43,682.4 мянган төгрөгийн өглөгийг, төсөв зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлээгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн

4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 заалттай нийцээгүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна" гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5.6 сая төгрөгийн зөрчилд 2 заалт, шилэн данстай холбоотой 1 заалт, нийт 3 заалт бүхий зөвлөмж өгч, 2 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, шилэн данстай холбоотой 1 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75,298.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.861.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,549.5 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж, 31,887.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 556,870.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 1,786.6 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 7,267.0 мянган төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 6,180.0 мянган төгрөгийн, үндсэн хөрөнгийн тодруулгад 6,667.2 мянган төгрөгийн, бараа материалын тодруулгад 14,960.8 мянган төгрөгийн, нийт 36,861.6 мянган төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Ковидын зардлаас 1,565.0 мянган төгрөгөөр албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авч олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

### 4.3 Албан шаардлага

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 143 мэдээллээс 23 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 273,018,724.00 төгрөгийн орлого, 155,565,524.00 төгрөгийн зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 84,603,400.00 төгрөгийн авлага, 43,682,384.00 төгрөгийн өглөг, болон төсөв зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх онд өгөгдсөн шилэн данстай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *1,803.9 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, ангилал, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

***1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:***

- ✓ *Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримтлан ажиллаж, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх;*

***2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

- ✓ *4,745.6 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

*2.2. Өгсөн зөвлөмж:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

*/сая. төг/*

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудал** | | | | | | | | | | | |
| 1 | Алдархаан сумын Эрүүл мэндийн төв | 8 | 75.3 | 4 | 36.9 | 2 | 31.9 | | | 2 | 6.5 |
| | **Дүн** | **8** | **75.3** | **4** | **36.9** | **2** | **31.9** | | | **2** | **6.5** |
| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | | |
| 2 | Алдархаан сумын Эрүүл мэндийн төв | 1 | 556.9 | | | | | 1 | 556.9 | | |
| | **Дүн** | **1** | **556.9** | | | | | **1** | **556.9** | | |
| | **Нийт дүн** | **9** | **632.2** | **4** | **36.9** | **2** | **31.9** | **1** | **556.9** | **2** | **6.5** |